



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Г Сургалтын төрийн сангийн зээл, амжиргааны тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, “Монголын балетийн хөгжил сан”-гийн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Бямбацэрэн овогтой Халиунааг АНУ-ын Boston Ballet School-д суралцахад дэмжлэг үзүүлж, амжиргааны тэтгэлэгт нь шаардагдах 6500 /Зургаан мянга таван зуу/ ам.долларыг Сургалтын төрийн сангаас нэг удаа санхүүжүүлсүгэй.

2.Монгол банкны захиалгаар Английн Лондонгийн их сургуулийн докторантурт Санхүү эдийн засгийн чиглэлээр суралцаж буй Данзанбалжирын Энхжаргалын 2010-2011 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн зээлийг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлсүгэй.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 394 дүгээр тушаалын “Монгол банкны захиалгаар Данзанбалжирын Энхжаргалыг Английн Лондонгийн их сургуулийн докторантурт Санхүү эдийн засгийн чиглэлээр 2 жилийн” гэснийг, “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 405 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР

